

**Өлгий сумын ЗДТГ-ын 05-р сарын 10-с эхлэн 7 хоногт
хийсэн ажлын мэдээлэл**

2019-05-16

- Аймаг сумын ОНХСангийн хөрөнгөөр хийгдэх бүтээн байгуулалтын ажлын бэлтгэл ажил бүрэн хангагдаж гүйцэтгэгч шалгаруулалтын ажил эхэлж байна.
- ЗДТГазрын төрийн жинхэнэ албан хаагчдын ажлын байрны тодорхойлолтыг шинэчилж аймагт хүргүүлэв.
- Аймгийн ЗДТГазар МХГазртай хамтран хүнсний аюулгүй байдлыг хангуулах ажилд бүх багийн Засаг дарга болон тамгын газрын ажилтнууд оролцов.
- Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг шинэчлэн гаргаж аймагт хүргүүлэв.
- Бямба гарагт бүх нийтийн мод тарих талаар бүх албан байгууллага, аж ахуйн нэгжүүдэд албан тоот хүргүүлж орон нутгийн радиогаар ард иргэдэд сарын аяны ажлын талаар ухуулгаа сурталчилгаа хийв.
- “Эрүүл хүнс” сарын аяны хүрээнд ААНБ, сургууль цэцэрлэгүүдээр явж хяналт шалгалт хийж байгаа.
- Дэлхий зөн ОУБ-ын үйл үнэлгээ, төлөвлөлтийн үйл ажиллагаанд баг тус бүрээс 5 хүн нийт 60 хүнийг оролцуулсан болно.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн судалгаа болон баг тус бүрээс нэн ядуу 10 өрхийн судалгааг гаргаж өгөв.
- Статистикийн хэлтэст “Сэтгэл ханамж”-д хамрагдах өрхийн судалгааг гаргаж байршлыг нь тогтоож өгөв.
- 5. ГБХЗХГ ирсэн албан бичгийн дагуу “Хүүхдийн хүмүүжлийн эерэг аргад суралцъя”, хүүхдийн тусламжийн утас 108-тай холбоотой 30ширхэг стикерийг сургууль, цэцэрлэг, олон нийтийн газарт байрлуулан сурталчлан ажилласан болно.
- 2,3,9,12-р багуудад шинээр хатуу хучилттай зам тавигдаж байгаа тул ажлын комисстэй хамтарч ажиллаж байна.
- 8 дугаар багийн ногоон хашааны дотор дур мэдэн хашаа татаж байгаа айл өрхүүдэд мэдэгдэх хуудас тарааж ажиллав.
- Гудамж зам талбайн цэвэрлэгээ хийж 5тн хог ачиж хогийн цэгт хүргэв.
- Гудамж зам талбайг шөнийн гэрэлтүүлгээр хангаж, төв талбайн гэрэлтүүлгийн урсгал засваруудыг хийж шөнийн гэрэлтүүлгээр хангаж байна.
- СӨХ-ны хогийг ачиж орон сууц орчмын цэвэрлэгээ хийж, хог шатаах явдалд хяналт тавьж ажиллаж байна.
- Цэцэг тарих ажлыг хийж цэцгийн мандлуудыг усалж байна.
- Цэнгэлдэх хүрээлэнгийн талбайг услах ажил хийж байна.
- Ногоон бүсийн хашаануудын усалгааны ажил хийж байна.

ӨЛГИЙ СУМЫН ЗДТГ